

2025 оны 04 сарын 15 өдөр

№ 02

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр
хуралдуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.1 болон 64.2 дахь хэсэг, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.3 дахь хэсэг, Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын хоёрдугаар зүйл мөн журмын гуравдугаар зүйл болон дөрөвдүгээр зүйлд заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 сарын 23-ны өдөр 14:00 цагт өөрийн байрнаас цахим хэлбэрээр шууд дамжуулан хуралдуулсугай.
2. Дээрх хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:
 - ✓ 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - ✓ Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
 - ✓ Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг батлах;
 - ✓ Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг хэлэлцэн батлах;
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 сарын 07-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай мэдэгдлийг “Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж”-д мэдэгдэх өдрийг 2025 оны 03 сарын 14-ний өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2025 оны 03 сарын 18-ны өдөр болон 2025 оны 04 сарын 02-ны өдрүүдэд байхаар тогтоосугай.
5. Хурал хуралдуулах тухай зарыг 2025 оны 03 сарын 18-ны өдөр Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, 2025.03.18-ны өдөр болон 2025.04.02-ны өдрүүдэд өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио телевизээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Дараах бичиг баримтуудыг компани дээр 2025.03.20-ны дотор бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах, 2025.03.21-ны дотор брокер, дилерийн компанид хүргүүлэх ажлыг зохион байгуулсугай. Үүнд:
 - 6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр;
 - 6.2. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах талаар нийтэд мэдээлэх зарын загвар;
 - 6.3. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын хуулбар;
 - 6.4. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны бизнес төлөвлөгөө;
 - 6.5. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, хөндлөнгийн аудитын дүгнэлт;

- 6.6.Хувьцаа эзэмшигчдийн санал хураах хуудас;
 6.7.Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв;
7. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2025.04.23-ны өдрийн 13:00 цагаар тогтоосугай.
 8. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарын загварыг энэхүү тогтоолын хавсралт №1-ээр баталсугай.
 9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарын санал хураах хуудасны загварыг энэхүү тогтоолын хавсралт №2-оор баталсугай.
 10. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг энэхүү тогтоолын хавсралт №3-аар баталсугай.
 11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Дэд захирал П.Адьяахүү, хурлын нарийн бичгийн даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга И.Өлзийбаяр, тэргүүлэгчдээр хувьцаа эзэмшигч Д.Самдан, Ж.Сүхболд нарыг сонгосугай.
 12. Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:	Ч.Мөнх-Очир	/Нягтлан бодогч/
Комиссын гишүүд:	Г.Урангуа	/Нягтлан бодогч/
	Б.Хонгорзул	/Нягтлан бодогч/
 13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:	Н.Одгэрэл	/Үйлдвэрийн дарга/
Нарийн бичгийн дарга:	И.Өлзийбаяр	/ТУЗ нарийн бичгийн дарга/
Гишүүд:	Н.Маралсүрэн	/Ерөнхий инженер/
	Г.Тэмүүлэн	/Маркетингийн албаны дарга/
	Х.Содгэрэл	/Захиргаа, хүний нөөцийн албаны дарга/
 14. Компанийн хувьцаа эзэмшигчдэд хурлын материал, танилцуулгыг тараах, хурлын бэлтгэл ажлыг сайтар зохион байгуулж ажиллахыг Хурал зохион байгуулах комиссын дарга /Н.Одгэрэл/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.ЦЭНГҮҮН

“Мах-импэкс” ХК-ийн 2025 оны 03 сарын 13-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2 тоот тогтоолын Хавсралт №1



**“МАХ-ИМПЭКС” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР**

1. Компанийн оноосон нэр: “Мах-импэкс” ХК
2. Компанийн байршил: Сонгинохайрхан дүүрэг, 4-р хороо, Хүнсчдийн гудамж
3. Хурал хийх өдөр: 2025.04.23 өдөр 14:00 цагаас компанийн фэйсбүүк пэйж хуудсаар цахим хэлбэрээр шууд дамжуулан хуралдана.
4. Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2025.04.07
5. Хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:
 - 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
 - Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг батлах;
 - Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг хэлэлцэн батлах;
6. Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2025.03.24-ны өдрөөс 2025.04.23-ны өдрийн 13:00 цаг хүртэл ажлын өдрүүдэд 10-16 цагийн хороонд компанийн өөрийн байранд ирж хурал зохион байгуулах комиссоор дамжуулан танилцах эсхүл Компанийн www.makhimpex.mn сайтаар дамжуулан цахимаар танилцах, саналаа өгөх боломжтой.
7. Хурал зохион байгуулах комиссын нарийн бичгийн дарга И.Өлзийбаяр
/Утас: 99134516, 86003200/

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

**“МАХ-ИМПЭКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**


1. Компанийн нэр: “Мах-Импэкс” ХК
2. Хурал хийх өдөр: 2025.04.23 өдөр 14:00 цагаас компанийн фэйсбүүк пэйж хуудсаар цахим хэлбэрээр шууд дамжуулан хуралдана.
3. Хувьцаа эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр:
4. Өөрийн нэр:
5. Хувьцааны төрөл: Энгийн,
6. Хувьцааны тоо:
7. Регистрийн дугаар:
8. Та ээлжит хурлаар шийдвэрлэх асуудалд саналаа өгөхдөө харгалзах нүдэнд “+” тэмдгээр тэмдэглэнэ үү.

№	Шийдвэрлэх асуудал	Зөвшөөрсөн	Түдгэлзсэн	Татгалзсан бол саналаа бичнэ үү
1	2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлахыг			
2	Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахыг			
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв			
4	Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг хэлэлцэн батлах			

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг.....

Тооллогын комисс саналын хуудсыг хүчингүй болгосон бол шалтшаан:

.....
.....



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

1. Хурлын ирцийг мэдээлэх, “Хурал хүчин төгөлдөрт тооцох тухай” Тооллогын Комиссын тогтоолыг танилцуулах
/Тооллогын Комиссын дарга Ч.Мөнх-Очир/ 5 минут
2. Хурлын дарга П.Адьяахүү хурлыг нээж үг хэлэх 5 минут
3. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны бизнес төлөвлөгөөг танилцуулах /Гүйцэтгэх захирал Г.Бүдрагчаа/ 15 минут
4. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулан илтгэх
/Ерөнхий нягтлан бодогч С.Мөнхжаргал/ 25 минут
5. Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийг танилцуулах
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга И.Өлзийбаяр/ 3 минут
6. “Ногдол ашиг хуваарилах тухай” ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга И.Өлзийбаяр/ 3 минут
7. Хэлэлцэж буй асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт 10 минут
8. Санал хураалт /Тооллогын комисс санал тоолох/ 15 минут
9. Тооллогын комиссын шийдвэрийг уншиж сонсгох
/Тооллогын комиссын дарга Ч.Мөнх-Очир/ 5 минут
10. Хурлаас гарах шийдвэрийг танилцуулах, хурлыг хааж үг хэлэх
/Хурлын дарга П.Адьяахүү/ 10 минут

Тайлбар: Хурлыг 1:30 цагт багтаана.